

# ХЯТАД ДАХЬ ЗҮҮН ХОЙТ АЗИ СУДЛАЛ

Ц. Баатар, Г. Гунгаа

Хятад улс орон судлалын эртний уламжлалтай, арвин баялаг туршлагатай орны нэг. Аль ч төрийн үед орон судлалд онцгой анхаарал тавьж, хөрш олон харилцах орныхоо түүх, соёл, нийгэм—эдийн засгийн байдал, улс төрийн тогтолцоо, геополитикийн онцлог зэрэг цогц асуудлыг олон талаас нь нарийн нягт судалж үзсэний үндсэн дээр өөрийн бодлогоо тодорхойлж иржээ. Сүүлийн үед Хятад улс орон судлалын уламжлалдаа түшиглэж Зүүн хойт Ази судлалын асуудалд онцгой анхаарал тавьж бүс нутгийн асуудлыг тусгайлон судалдаг эрдэм шинжилгээний хүрээлэн, төвүүдийг ганцоор байгуулж, боловсон хүчин, материаллаг баазыг нь ихээхэн бэхжүүлж судалгааны ажлынхаа цар хүрээг ч өргөтгөж байна. Бүс нутгийн судалгаанд нэгэж их анхаарал тавих болсон нь ч учиртай. Энэ нь нэг талаар, Хятад улс Зүүн хойт Азийн бүс нутгийн орнуудтай харилцан ашигтай байх зорчимд тулгуурлан

---

Ц. Баатар, Г. Гунгаа—ШУА-ийн Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажлтан

худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөтгөн хөгжүүлэх, энд бүрэлдэж буй олон улсын хөдөлмөрийн хуваарьт гэдвхтэй оролдох, нөгөө талаар, Зүүн хойт Азийн бүс нутаг дахь БНХАУ-ын боллого нөлөө, түүний газарзүй, стратегийн байдал, хүчин чадлаараа уг бүс нутгийн олон улсын улс төр, эдийн засгийн бүтцэд зохих байр суурь эзэлж байгатай нягт уялдаа холбоотой гэж үзэж болох юм.

Өнөөгийн байдлаар Хятадын Нийгмийн шинжлэх ухааны Академийн Ази Номхон далай судлалын хүр элэн, Олон улсын техник, эдийн засгийн хүрээлэн, Орчин үеийн олон улсын харилцааны хүрээлэн, Ази Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн хүрээлэн, Дэлхийн эдийн засаг, улс төр судлалын хүрээлэн болон Зүүн хойт Хятадын бүс нутагт хамаарах Тяньжин хотын Зүүн хойт Азийн эдийн засгийн хүрээлэн, Жи Лишь мужийн Чан Чунь хотын Зүүн хойт Хятадын багийн их сургуулийн дэргэдэх Зүүн хойт Ази судлалын төв, Оросын Холбооны улс судлалын хүрээлэн, Жи Лишь их сургуулийн Солонгос судлалын хүрээлэн, Япон судлалын хүрээлэн, Олон улсын худалдаа, эдийн засгийн хүрээлэн, Хар мөрөн мужийн Нийгмийн шинжлэх ухааны академийн Сибирийн судлалын хүрээлэн, Хар мөрөн мужийн их сургуулийн эдийн засгийн хүрээлэнгээс гадна Ляонин мужийн нийгмийн шинжлэх ухааны Академи, Янтай их сургуулийн Зүүн Ази судлалын хүрээлэн, Бээжингийн их сургуулийн солонгос, япон, америк, судлалын төв, Өвөр Монголын их сургуулийн Монгол улсыг судлах хүрээлэн зэрэг 20 гаруй эрдэм шинжилгээний байгууллага Зүүн хойт Азийн орон судлалын асуудлаар хэсэгчилсэн буюу төрөлжиж дагнасан хэлбэрээр судалгааны ажил явуулж байна.

Бүс нутгийн судалгааны байгууллагуудын бэйршлыг авч үзвэл ихэнх нь Зүүн хойт Хятадад төвлөрч, нийгмийн шинжлэх ухааны академи, их, дээд сургууль, төрийн байгууллагуудыг түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байна. Судалгааны төв, хүрээлэнгүүдийн ажлыг Хятадын Төрийн зөвлөлийн дэргэдэх Судалгаа, хөгжлийн төв нэгтгэн зохидаж, уялдуулан зохицуулж байна.

Бүс нутгийн судалгааны төвүүд дэлхийн эдийн засагт Зүүн хойт Азийн эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг роль, бүс нутгийн өнөөгийн байдал хэтийн төлөв, улс дундын харилцаа, санхүү, худалдаа, техник, экологи, аюулгүй байдлыг хангах арга зам, дэд бүтцийн хөгжил, ажиллах хүч, нийгмийн асуудал, бүс нутаг дахь хятадын улс төр, эдийн засгийн сонирхол, эзлэх байр суурь хоёр талын болон олон талын хамтын ажиллагааг өргөтгөн хөгжүүлэх асуудлаа, бүс нутгийн чанартай эдийн засгийн чөлөөт бүс, элсэл байгуулах төсөл боловсруулах асуудал, бүс нутгийн орнуудын түүх, соёл, газарзүй, цаг уур, улс төрийн тогтолцоо дахь хурьцаа өөрчлөлт, нийгэм эдийн засгийн байдал, геополитикийн онцлог зэрэг олон чиглэлээр их бүрэн нэгцлөх судалгаа хийж байна. Энд зөвхөн Тяньжин хотын Зүүн хойт Азийн эдийн засгийн хүрээлэнг жишээ болгон авч үзье. Энэ хүрээлэнгийн судалгааны ажлын чиглэл нь Зүүн хойт Хятадын бүс нутгуудаас аж ахуй, нийгмийн харилцаа, байгаль газарзүйн хууль ёс хоорондоо уялдаа бүхий нэгдмэл тогтолцоог үүсгэж буй Тяньжин, Бээжин хот, Өвөр монгол, Хэбэй муж хоршиж ажиллах асуудал, эдийн засгийн хамтын ажиллагааны энэ бүсийг Монгол, Оросын Холбооны Улстай холбох, цаашдаа Хятадын эдийн засгийн дотоод сүлжээнд болон Зүүн хойт Азийн хамтын ажиллагаанд энэ бүсийн гүйцэтгэх үүрэг роль зэрэг өргөн цар хүрээтэй уялдаа холбоо бүхий нэгдсэн асуудлаар нэгдсэн судалгаа хийж үзвэл дүгнэлт өгөх жишээтэй байна. Энэ судалгаанд Өвөр монголын их сургуулийн Монгол улсыг судлах хүрээлэн зохих үүрэг гүйцэтгэж байна.

Дээрх судалгааны төвүүдийн ихэнх нь өөрийн гэсэн тусмал хөдөлгөөнтэй. Тухайлбал, Хятадын Нийгмийн шинжлэх ухааны академийн Ази Номхон далайн судлалын хүрээлэнгээс эрхлэн "Ази Номхон далайн судлал", Жи Лишийн их сургуулийн судалгааны төв "Зүүн хойт Ази судлалын төв", Гадаад орон судлалын асуудал" зэрэг тогтмол сэтгүүл

гаргаж, судалгааны ажлын явц, үр дүнг олон нийтэд хүргэж байна. Түүнчлэн бүс нутгийн эдийн засгийн асуудлаар судалгаа хийдэг эрдэмтдийн бүтээлийг "Зүүн хойт Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа" гэсэн цуврал ном болгон эмхэтгэж тогтмол хэвлэн нийтэлж өргөн олны хүртээл болгож байна.

**БНМАУ** дахь Зүүн хойт Ази судлалын төсүүдийн тухай бидэнд олдож буй материалын хэмжээнд тойм төдий өгүүлэхэд нийм байна.